



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/158

Улаанбаатар хот

Томилгоот хуваарьт шилжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/490 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг сайжруулах, албаны бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалтаар худалдан авсан Уаз-22069 маркийн 2 ширхэг автомашин олгох хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Баталсан хуваарийн дагуу Уаз-22069 маркийн автомашиныг нийслэлийн Аврах анги 105, Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэст хүлээлгэн өгөхийг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

3. Хүлээн авсан 70,000,000 (далан сая) төгрөгийн өртөг бүхий Уаз-22069 маркийн 2 ширхэг автомашиныг холбогдох хууль тогтоомжийн дагуу тайлан бүртгэлдээ тусгаж ажиллахыг нийслэлийн Онцгой байдлын газрын Өмч хамгаалах байнгын зөвлөл (хурандаа Н.Нямхорлоо)-д, Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс (дэд хурандаа Л.Чинбат)-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА  Ж.ЧҮЛТЭМСҮРЭН





Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн
А/138 дугаар тушаалын хавсралт

АВТОМАШИНУУДЫГ ОЛГОХ ХУВААРЬ

д/д	Автомашинны марк	Улсын дугаар	Үйлдвэрлэгч Улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ	Олгох байгууллага
1	Уаз-22069	65-79 УАЕ	ОХУ	1	35.000.000	35.000.000	Налайх дүүргийн ОБХ
2		68-79 УАА		1	35.000.000	35.000.000	Нийслэлийн аврах анги-105
		ДҮН		2	70.000.000	70.000.000	

--oOo--